



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/412

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дах хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны XV дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Халдварт өвчнөөс сэргийлэх хянах арга хэмжээний хүрээнд “Төгс бүсгүйчүүд” Төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад шаардлагатай зардалд 5,000.000 (Таван сая), “Дархад их хурд” хурдан морины наадамд шаардлагатай зардал 1, 920.000 (Нэг сая есөн зуун хорин мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 6.920.000 (Зургаан сая есөн зуун хорин мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний” зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ